**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ӨМА-2023/122/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Даланзадгад хот<br>2023 он | Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр<br>Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Т.Хонгорзул<br>Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: Ж.Болормаа<br>Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn<br><br>Аудитор: С.Одончимэг<br>Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.02.24 № 189

танай ______________-ны №______________ -т

ДАЛАНЗАДГАД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА А.ГАНЗУУЗАЙ ТАНАА

## Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Даланзадгад сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Даланзадгад сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

## Асуудлын онцолсон хэсэг

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 9/64 дүгээр тогтоолоор Говийн Ирээдүй ОНӨААТҮГ-ын 9,239.0 сая төгрөгийн хөрөнгийг Орон нутгийн өмчийн газарт балансаас балансt шилжүүлсэн байна.

## Аудитын гол асуудал

Орон нутгийн төсвөөс санхүүжих урсгал үйл ажиллагааны санхүүжилт 9,626.1 сая төгрөг болж өмнөх оноос 7,038.3 сая төгрөгөөр буюу 3.7 дахин өссөн байна.

## Бусад асуудлын хэсэг

Төрийн үйлчилгээний чанар хүртээмж, бүтээмжийг нэмэгдүүлэхээр Чанарын удирдлагын тогтолцооны ISO9001:2015 стандартыг хэрэгжүүлэн үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна.

016020254

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ӨСӨХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **644,313,141.92** | **624,229,387.32** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 634,513,141.92 | 388,983,592.32 |
| **354** | **Хангамжийн материал** | 634,513,141.92 | 388,983,592.32 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 246,300.00 | 1,276,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 33,297,615.72 | 177,981,602.32 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,910,000.00 | 3,152,140.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 598,059,226.20 | 206,573,350.00 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | 9,800,000.00 | 235,245,795.00 |
| 36800 | Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/ | 9,800,000.00 | 235,245,795.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **16,767,440,134.53** | **11,258,088,237.40** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 16,767,440,134.53 | 11,258,088,237.40 |
| **392** | **Биет хөрөнгө** | 14,864,749,134.45 | 10,855,827,237.28 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 10,120,604,751.00 | 10,182,397,793.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (620,836,780.99) | (743,755,961.15) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 522,124,800.00 | 529,124,800.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (306,536,472.12) | (371,112,827.40) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 482,156,173.00 | 780,003,373.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (218,032,065.16) | (294,379,186.25) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 390,949,468.83 | 563,836,313.83 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (129,208,315.88) | (156,378,811.19) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 7,581,069,553.00 | 513,583,347.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (2,957,541,977.23) | (147,491,603.56) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 1,902,691,000.08 | 402,261,000.12 |
| 39301 | Програм хангамж | 2,150,000.00 | 2,150,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (859,999.92) | (1,289,999.88) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,901,401,000.00 | 401,401,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **17,411,753,276.45** | **11,882,317,624.72** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **48,762,749.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 48,762,749.00 |
| **413** | **Өглөг** | - | 48,762,749.00 |
| 41340 | Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг | - | 48,762,749.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **17,411,753,276.45** | **11,833,554,875.72** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 17,411,753,276.45 | 11,833,554,875.72 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 10,202,350,064.19 | 8,702,350,064.19 |
| 51101 | Өмч: - төрийн | 10,202,350,064.19 | 8,702,350,064.19 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 7,159,870,119.19 | 3,086,377,772.05 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 7,159,870,119.19 | 7,164,576,172.78 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (4,078,198,400.73) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 49,533,093.07 | 44,827,039.48 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **17,411,753,276.45** | **11,882,317,624.72** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,999,331,350.00** | **9,787,930,049.00** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **-** | **-** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **5,721,819.00** | **3,223,088.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 5,721,819.00 | 3,223,088.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 5,721,819.00 | 3,223,088.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,721,819.00 | 3,223,088.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,993,609,531.00** | **9,784,706,961.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 405,787,131.00 | 158,619,861.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 292,292,235.00 | 134,447,650.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,216,906.00 | 11,101,106.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 110,277,990.00 | 13,071,105.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 2,587,822,400.00 | 9,626,087,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 2,587,822,400.00 | 9,626,087,100.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **4,391,298,866.08** | **10,487,901,449.52** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,388,798,866.08** | **10,487,901,449.52** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 3,682,734,712.52 | 7,611,351,398.27 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 581,136,784.00 | 577,927,417.00 |
| 210101 | Үндсэн цалин | 400,807,956.00 | 403,849,320.00 |
| 210102 | Нэмэгдэл | 94,429,459.00 | 89,710,097.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 85,899,369.00 | 84,368,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 76,583,925.14 | 74,212,772.07 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 53,905,153.16 | 51,559,663.24 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,021,135.79 | 6,066,406.77 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,715,776.79 | 4,651,527.80 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,085,698.12 | 1,085,048.50 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,856,161.28 | 10,850,125.76 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 208,601,271.60 | 207,564,736.63 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 21,776,542.20 | 22,784,738.63 |
| 210302 | Түлш, халаалт | 151,003,121.40 | 154,980,082.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 35,821,608.00 | 29,799,916.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 319,729,993.00 | 2,682,702,091.45 |
| 210401 | Бичиг хэрэг | 12,205,500.00 | 31,958,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 44,412,130.00 | 90,040,646.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 19,811,053.00 | 27,123,037.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 9,900,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 34,408,410.00 | 27,512,673.00 |
| 210409 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/ | 198,992,900.00 | 2,506,067,035.45 |
| **2105** | **Нормативт зардал** | 21,279,000.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 21,279,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 50,497,710.00 | 78,700,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,775,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 44,722,710.00 | 78,700,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,692,000.00 | 15,069,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,692,000.00 | 15,069,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 957,282,284.00 | 2,792,965,201.20 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 957,282,284.00 | 2,792,965,201.20 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,462,931,744.78 | 1,182,210,179.92 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 300,543,551.00 | 107,805,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 22,297,350.00 | 26,894,033.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 1,140,090,843.78 | 1,047,511,146.92 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 706,064,153.56 | 2,876,550,051.25 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 57,409,042.30 | 75,907,879.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 6,313,242.00 | 25,105,968.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 51,095,800.30 | 50,801,911.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 648,655,111.26 | 2,800,642,172.25 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 648,655,111.26 | 2,800,642,172.25 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **2,500,000.00** | **-** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 2,500,000.00 | - |
| 223001 | Бусад хөрөнгө | 2,500,000.00 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(1,391,967,516.08)** | **(699,971,400.52)** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | - | - |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 9,007,400.63 | 4,295,668,301.21 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 8,607,400.63 | 4,295,668,301.21 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 400,000.00 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (9,007,400.63) | (4,295,668,301.21) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(1,400,974,916.71)** | **(4,995,639,701.73)** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **3,036,525,503.00** | **9,787,930,049.00** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **-** | **-** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **5,721,819.00** | **3,223,088.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 5,721,819.00 | 3,223,088.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 5,721,819.00 | 3,223,088.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,721,819.00 | 3,223,088.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,030,803,684.00** | **9,784,706,961.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 442,981,284.00 | 158,619,861.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 292,292,235.00 | 134,447,650.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,216,906.00 | 11,101,106.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 147,472,143.00 | 13,071,105.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 2,587,822,400.00 | 9,626,087,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 2,587,822,400.00 | 9,626,087,100.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,840,553,775.30** | **6,999,030,405.95** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,840,553,775.30** | **6,999,030,405.95** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,134,489,621.74** | **4,122,480,354.70** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 581,136,784.00 | 577,927,417.00 |
| 210101 | Үндсэн цалин | 400,807,956.00 | 355,880,437.00 |
| 210102 | Нэмэгдэл | 94,429,459.00 | 103,715,316.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 85,899,369.00 | 98,478,128.00 |
| 210104 | Урамшуулал | - | 19,853,536.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 76,583,925.14 | 74,212,772.07 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 53,905,153.16 | 51,844,039.98 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,021,135.79 | 6,308,162.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,715,776.79 | 4,179,834.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,085,698.12 | 1,083,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,856,161.28 | 10,797,036.09 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 205,801,271.60 | 207,564,736.63 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 21,776,542.20 | 22,784,738.63 |
| 210302 | Түлш, халаалт | 148,203,121.40 | 154,980,082.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 35,821,608.00 | 29,799,916.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 104,314,216.00 | 175,492,708.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 12,604,600.00 | 28,734,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 49,101,810.00 | 70,714,386.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 19,811,053.00 | 27,123,037.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 22,796,753.00 | 48,920,785.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 51,700,030.00 | 78,700,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,755,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 43,945,030.00 | 78,700,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,692,000.00 | 15,069,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,692,000.00 | 15,069,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 796,240,741.00 | 2,858,665,788.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 796,240,741.00 | 2,858,665,788.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 314,020,654.00 | 134,847,933.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 291,943,304.00 | 107,805,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 22,077,350.00 | 27,042,933.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **706,064,153.56** | **2,876,550,051.25** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 57,409,042.30 | 75,907,879.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 6,313,242.00 | 25,105,968.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 51,095,800.30 | 50,801,911.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 648,655,111.26 | 2,800,642,172.25 |

| | | | |
|---|---|---|---|
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 648,655,111.26 | 2,800,642,172.25 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **195,971,727.70** | **2,788,899,643.05** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **194,139,618.00** | **2,786,873,138.05** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **194,139,618.00** | **2,786,873,138.05** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 194,139,618.00 | 2,786,873,138.05 |
| 223001 | Бусад хөрөнгө | 164,058,026.00 | 2,428,145,693.05 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 30,081,592.00 | 358,727,445.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(194,139,618.00)** | **(2,786,873,138.05)** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 1,832,109.70 | 2,026,505.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **10,202,350,064.19** | **49,533,093.07** | **7,159,870,119.19** | 17,411,753,276.45 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 4,706,053.59 | 4,706,053.59 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **10,202,350,064.19** | **49,533,093.07** | **7,164,576,172.78** | 17,416,459,330.04 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | (4,706,053.59) | - | (4,706,053.59) |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | (1,500,000,000.00) | - | - | (1,500,000,000.00) |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (4,078,198,400.73) | (4,078,198,400.73) |
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **8,702,350,064.19** | **44,827,039.48** | **3,086,377,772.05** | 11,833,554,875.72 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 9,630,087,100.00 | 6,828,668,015.75 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 5,506,485,400.00 | 4,145,932,322.70 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 5,446,485,400.00 | 4,091,096,893.70 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 724,088,000.00 | 577,927,417.00 |
| 210101 | Үндсэн цалин | 438,468,000.00 | 355,880,437.00 |
| 210102 | Нэмэгдэл | 140,700,000.00 | 103,715,316.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 114,540,000.00 | 98,478,128.00 |
| 210104 | Урамшуулал | 30,380,000.00 | 19,853,536.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 97,751,900.00 | 74,212,772.07 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 68,788,300.00 | 51,844,039.98 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,240,900.00 | 6,308,162.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,792,700.00 | 4,179,834.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,448,200.00 | 1,083,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,481,800.00 | 10,797,036.09 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 275,507,900.00 | 207,564,736.63 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 37,307,900.00 | 22,784,738.63 |
| 210302 | Түлш, халаалт | 195,000,000.00 | 154,980,082.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 43,200,000.00 | 29,799,916.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 192,125,400.00 | 168,160,102.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 46,100,000.00 | 26,354,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 65,800,000.00 | 65,791,780.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 27,800,000.00 | 27,093,037.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 52,425,400.00 | 48,920,785.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 120,000,000.00 | 119,994,900.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 50,000,000.00 | 49,994,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 70,000,000.00 | 70,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 20,000,000.00 | 15,069,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 20,000,000.00 | 15,069,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,973,012,200.00 | 2,901,125,033.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,973,012,200.00 | 2,901,125,033.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 44,000,000.00 | 27,042,933.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 44,000,000.00 | 27,042,933.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 60,000,000.00 | 54,835,429.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 60,000,000.00 | 54,835,429.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 30,000,000.00 | 25,105,968.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 30,000,000.00 | 29,729,461.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **4,123,601,700.00** | **2,682,735,693.05** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 4,123,601,700.00 | 2,682,735,693.05 |
| 223001 | Бусад хөрөнгө | 4,123,601,700.00 | 2,682,735,693.05 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 9,630,087,100.00 | 6,828,668,015.75 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 9,626,087,100.00 | 6,825,444,927.75 |

| | | | |
|---|---|---|---|
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 9,626,087,100.00 | 6,825,444,927.75 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 4,000,000.00 | 3,223,088.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,000,000.00 | 3,223,088.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | - |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **156,593,356.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **156,593,356.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 135,520,906.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,332,606.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,380,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,922,606.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 30,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 18,664,800.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 9,964,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,700,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,718,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,718,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 107,805,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 107,805,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 21,072,450.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 21,072,450.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 21,072,450.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 158,619,861.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 158,619,861.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 134,447,650.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 11,101,106.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 13,071,105.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,776.1 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 4,776.1 сая төгрөгийн алдааг залруулж ажилласан. Үүнд:

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Аймгийн ИТХ-ын 2022 оны 9/64 дүгээр тогтоолоор ОНӨГ-т эзэмшлийн газар шилжүүлэхдээ Засгийн газрын санг бууруулж тайлагнаагүй
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд үндсэн данснаас төвлөрүүлсэн шилжүүлгээр, санхүүжилтийн эх үүсвэрийг бууруулж тайлагнаагүй
- Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн, худалдан авсан хөрөнгийг дутуу тайлагнасан
- Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ЗДТГ-ын гал тогооны засвар, нийтийн эзэмшлийн хэсэгчлэн WIFI орчинтой болгох, 4 сургуулийн өргөтгөлийн зураг төсөв, нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, 1 сургуулийн заалны зураг төсвийн ажлын гүйцэтгэлийг тус тус эргэлтийн хөрөнгөөр бүртгэж тайлагнаагүй байна.

Аудитаар нийт 43.3 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 26.9 сая төгрөгийн 2 зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 16.4 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж өгсөн.

**5.1 Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй байна.

**5.2 Албан шаардлага**

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай ЗГ-ын тогтоол батлагдаж суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтныг хязгаарласан ч ЗДТГ-ын албан хаагчдад шатахуун олгож, тээврийн хэрэгсэл ашиглуулж ажилласан байна.
- 210406 БҮТЭЗ зардлаас багийн төвүүдэд камер, байгууллагад ус цэвэршүүлэгч, ус буцалгагч, зөөврийн кондейшн, хөшиг, баримт үдэгч, хард диск гэх мэт эд хогшлууд бэлтгэсэн байна

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 "*Аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно",* Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах",* 16 дугаар зүйлийн 16.5.5 "*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах",* Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "*Зардлын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"*-д заасантай тус тус нийцэхгүй байна.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал**

*<u>Илрүүлэлт 1</u>:* Малын өвс тэжээл, хүнсний материалыг бусад хангамжийн материал дансанд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 /үнэн зөв байх/ болон санхүүгийн тайлагналын толилуулга, ангилал гэсэн баталж мэдэгдлийг хангахгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж</u>*: УСНББОУС 1,12 дагуу бүртгэл хөтөлж, бараа материалыг зохих ангилал, дансанд залруулж ажиллах зөвлөмж хүргүүлэх

*<u>Илрүүлэлт 2</u>:* Бараа, үйлчилгээний худалдан авалтын төлбөрийн Е баримтын зардлыг барааны нэр төрөл, тоо ширхгээр гаргуулаагүй, бөөн дүнгээр шивүүлж, анхан шатны баримтад хавсарсан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх"-д заасантай нийцэхгүй байна.

---

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*Өгсөн зөвлөмж*: Бараа, үйлчилгээ худалдан авалт хийх тухай бүрд борлуулагчийн хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг кассын машинаас хэвлүүлэн авч анхан шатны баримтад хавсаргаж ажиллах

**2. Хууль тогтоомжтой холбоотой асуудал**

*Илрүүлэлт 1:* Байгууллагын хөрөнгөөр АЙ СИ БИ СИ ХХК, БЭСТ компьютер технологи ХХК-уудаас компьютер, техник хэрэгслүүдийг шууд худалдан авч, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, шаардлагатай бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлт хүргүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 14.4 "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлж, цаашид цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг цахим дэлгүүрээс худалдан авч ажиллах

*Илрүүлэлт 2:* Байгууллагын дотоод журмыг үндэслэн албан хаагчдад нэг удаагийн буцалтгүй тусламж,тэтгэмж урамшуулал олгохдоо ХХОАТ суутгаагүй байна.

Энэ нь Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/261 дүгээр тушаалаар баталсан "Хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх, албан татварын хөнгөлөлт эдлүүлэх журам"-ын 2.2 /Суутган төлөгч нь хууль тогтоомжид тусгайлан заагаагүй “Хөдөлмөрийн дотоод журам” зэрэг зөвхөн тухайн байгууллагын баримт бичиг, шийдвэрийг үндэслэн олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламжийг албан татвараас чөлөөлөхгүй/-д заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Хууль тогтоомжид тусгайлан заагаагүй “Хөдөлмөрийн дотоод журам” зэрэг зөвхөн тухайн байгууллагын баримт бичиг, шийдвэрийг үндэслэн олгосон тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламжаас хувь хүний орлогын албан татвар суутган тооцож төсөвт төвлөрүүлж ажиллах

*Илрүүлэлт 3:* Ажилчдын хүүхдийн баярын бэлэг, байгууллагын шилдэг ажилчдын шагналыг байгууллагын албан хаагчийн хувь данс руу шилжүүлэн хөрөнгө зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 3.1 "Төсөвт байгууллага нь Төрийн сангийн бүртгэлийн данснаас байгууллагын төлбөрийн картын дансаар дамжуулан бэлэн мөнгийг байгууллагын касст хүлээн авч зориулалтын дагуу зарцуулах үүргийг хүлээнэ"-д заасантай тус тус нийцэхгүй байна..

*Өгсөн зөвлөмж*: Зайлшгүй тохиолдолд төсвийн байгууллага нь арилжааны банкны төлбөрийн картын дансанд байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай бэлэн мөнгийг төрийн сангаас баталсан хязгаар/ЖМС/-ын дотор шилжүүлэн зориулалтын дагуу зарцуулж ажиллах

**3. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал**

*Илрүүлэлт 1:* Даланзадгад сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны А/43 дугаар тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжуудтай нийцүүлж шинэчлэн батлуулаагүй байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 "Ажил олгогч ажилтны төлөөлөгчийн саналыг харгалзан хууль тогтоомжид нийцүүлэн тухайн аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд үйлчлэх хөдөлмөрийн дотоод журмыг баталж мөрдүүлнэ"-д заасантай нийцэхгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж</u>*: Хөдөлмөрийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад хууль тогтоомжтой нийцүүлж "Хөдөлмөрийн дотоод журам"-аа шинэчлэн баталж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитыг газарт 2023 оны 10 дугаар сарын 02-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Аймгийн ИТХ-ын 2022 оны 9/64 дүгээр тогтоолоор ОНӨГ-т эзэмшлийн газар шилжүүлэхдээ Засгийн газрын санг бууруулж тайлагнаагүй байна | 1 | 1,500,000.0 | | | 1 | 1,500,000.0 | 1 | 1,500,000.0 | | | | |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланд үндсэн данснаас төвлөрүүлсэн шилжүүлгээр, санхүүжилтийн эх үүсвэрийг бууруулж тайлагнаагүй байна. | 1 | 2,800,642.2 | | | 1 | 2,800,642.2 | 1 | 2,800,642.2 | | | | |
| Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн, худалдан авсан хөрөнгийг дутуу тайлагнасан байна. | 1 | 298.767.7 | | | 1 | 298.767.7 | 1 | 298.767.7 | | | | |
| Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ЗДТГ-ын гал тогооны засвар, нийтийн эзэмшлийн хэсэгчлэн WIFI орчинтой болгох, 4 сургуулийн өргөтгөлийн зураг төсөв, нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, 1 сургуулийн заалны зураг төсвийн ажлын гүйцэтгэлийг тус тус эргэлтийн хөрөнгөөр бүртгэж тайлагнаагүй байна | 1 | 176.683.0 | 1 | 176,683.0 | | | 1 | 176.683.0 | | | | |
| **ДҮН** | **4** | **4,776,092.9** | **1** | **176,683.0** | **3** | **4,599,409.9** | **4** | **4,776,092.9** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай ЗГ-ын тогтоол батлагдаж суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтныг хязгаарласан ч ЗДТГ-ын албан хаагчдад шатахуун олгож, тээврийн хэрэгсэл ашиглуулж ажилласан байна | 1 | 7,794.6 | | | 1 | 7,794.6 | | | | | | |
| 210406 БҮТЭЗ зардлаас багийн төвүүдэд камер, байгууллагад ус цэвэршүүлэгч, ус буцалгагч, зөөврийн кондейшн, хөшиг, баримт үдэгч, хард диск гэх мэт эд хогшлууд бэлтгэсэн байна | 1 | 19,188.5 | | | 1 | 19,188.5 | | | | | | |
| Малын өвс тэжээл, хүнсний материалыг бусад хангамжийн материал дансанд бүртгэсэн байна | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| Даланзадгад сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны А/43 дугаар тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжуудтай нийцүүлж шинэчлэн батлуулаагүй байна | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| Байгууллагын хөрөнгөөр АЙ СИ БИ СИ ХХК, БЭСТ компьютер технологи ХХК-уудаас компьютер, техник хэрэгслүүдийг шууд худалдан авч, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, шаардлагатай бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлт хүргүүлж ажиллаагүй байна | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| Байгууллагын дотоод журмыг үндэслэн албан хаагчдад нэг удаагийн буцалтгүй тусламж,тэтгэмж урамшуулал олгохдоо ХХОАТ суутгаагүй байна | 1 | 7,850.0 | | | | | 1 | 7,850.0 | | | | |
| Ажилчдын хүүхдийн баярын бэлэг, байгууллагын шилдэг ажилчдын шагналыг байгууллагын албан хаагчийн хувь данс руу шилжүүлэн хөрөнгө зарцуулсан байна | 1 | 8,500.0 | | | | | 1 | 8,500.0 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бараа, үйлчилгээний худалдан авалтын төлбөрийн Е баримтын зардлыг барааны нэр төрөл, too ширхгээр гаргуулаагүй, бөөн дүнгээр шивүүлж, анхан шатны баримтад хавсарсан байна. | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| **ДҮН** | **8** | **43,333.1** | | | **2** | **26,983.1** | **6** | **16,350.0** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Гэрээ хэлцэл байгуулах болон хөрөнгө зарцуулахдаа ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг хөтөлж шилэн дансанд байршуулаагүй байна | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| **Дүн** | **1** | **0** | | | | | **1** | **0** |